



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 0/10

Улаанбаатар хот


“Ай Ти Би Берлин-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, арга хэмжээг зохион байгуулах тухай” нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/158 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Холбооны Бүгд найрамдах Герман улсын Берлин хотод зохион байгуулагдах “Ай Ти Би Берлин-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 2023 оны 03 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд оролцоход шаардагдах төсвийг хавсралт ёсоор баталсугай.

2. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход шаардагдах 5,670 € /таван мянга зургаан зуун далан/ еврог холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.


3. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500067

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 03 сарын 02 өдрийн
✓ А/10 дүгээр тушаалийн нэгдүгээр хавсралт



**“АЙ ТИ БИ БЕРЛИН-2023” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД
ОРОЛЦОХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА**

2023 оны 03 дугаар сарын 02-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Өдөр	Нэгж үнэ	Нийт үнэ
Зохион байгуулалтын арга хэмжээ				
1	“АЙ ТИ БИ БЕРЛИН-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох зардал	03.07-03.09	5,670€	5,670€
Дүн				5,670€

--- оОо ---